Дэлгүүн сумын Эрүүл мэндийн төв Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэснийг зөрчсөн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлгүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.8 сая төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 29,430.52 | 1,081.14 | -28,349.38 |
| Авлага | 4,762.12 | 2,481.72 | -2,280.40 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 58,346.39 | 75,552.97 | 17,206.58 |
| Үндсэн хөрөнгө | 1,398,114.83 | 1,402,778.86 | 4,664.03 |
| **Нийт хөрөнгө** | **1,490,653.87** | **1,481,894.70** | **-8,759.17** |
| Өр төлбөр | 533.40 | 27,366.00 | 26,832.60 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,490,120.47 | 1,454,528.70 | -35,591.77 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,490,653.87** | **1,481,894.70** | **-8,759.17** |

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 1.1 сая төгрөг болж 29.4 сая төгрөгөөр буурсан байна.

Авлага дансанд оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн 4.7 сая төгрөгийн авлагатай ба тайлант онд шинээр Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн 2.5 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материалын данс оны эцэст 17.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 75.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эм боох материалын үлдэгдэл 30.2 сая, аж ахуйн материал 34.8 сая, хүнсний материалын үлдэгдэл 1.8 сая, бусад хангамжийн материал 10.5 сая төгрөг байна.

Төсвийн хөрөнгөөр 265.2 сая төгрөгийн материал худалдан авч, үнэ төлбөргүй 7.9 сая төгрөгийн бараа материал авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,402.8 сая төгрөг болж 4.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5.8 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 94.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 33.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -33.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны батлагдсан төсөв 1,312.4 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,236.4 сая, орон нутгийн төсвөөс 46.5 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 29.4 сая, нийт 1,312.4 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 1,236.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 46.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж, 29.4 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулахаар байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,130.7 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 46.5 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 28.3 сая төгрөгийг зарцуулж нийтдээ 1,204.1.7 сая төгрөгийн зарлага, санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,204.1 сая төгрөг буюу 92 хувьтай байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөвлөснөөс 105.7 сая төгрөгөөр бага санхүүжилт авсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэг иргэнд ногдох нормативаар | 847,645.20 | 834,469.33 | -13,175.87 | 98% |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 388,730.10 | 297,587.95 | -91,142.15 | 77% |
| 3 | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 29,430.50 | 27,337.71 | -2,092.79 | 93% |
| 4 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 46,548.50 | 44,704.43 | -1,844.07 | 96% |
| | **Дүн** | **1,312,354.30** | **1,204,099.43** | -108,254.87 | 92% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Эрүүл мэндийн төв нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 265.2 сая төгрөгийн бараа материал, 5.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,209.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 12.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 33 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10.7 сая төгрөгийн 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32.2 сая төгрөгийн 5 гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 38.7 сая төгрөгийн 3 шийдвэр, 27.4 сая төгрөгийн 6 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 898.3 сая төгрөгийн 26 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан, мэдээлсэн байдлын хэрэгжилт 65.9 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд байршуулаагүй мэдээлээгүй нөхөж байршуулж, зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 25.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг цахим худалдан авалтаар аваагүй зөрчилд албан шаардлага, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс 91.9 сая төгрөгийн 11 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 86.0 хувьтай, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 75 хувьтай, өмнөх оны аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг давтан гаргасан зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 25,757.3 | 1 | 25,757.3 | 100% |
| Зөвлөмж | 1 | 91,874.9 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | 2 | 117,632.2 | 1 | 25,757.3 | 50% |

Тайлант онд шилэн дансны зөрчлийн дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахад зөрчлийг арилгаагүй, давтан гаргасан тул албан шаардлага өгсөн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар тус байгууллагад их хэмжээний материаллаг алдаа, зөрчил илэрч, сөрөг дүгнэлт авсан тул давтан шалгалт хийх шаардлагатай. Санхүүгийн тайлангийн аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалт, цалингийн зардал, эмийн тайлан, тооцоо, нярвын тайланг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийтдээ 3.4 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс, 3.4 сая төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

НДШ-ийн 0.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан, төсвийн гүйцэтгэлийн тайланд халаалтын зардлын гүйцэтгэлийг 1.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан, орон нутгаас санхүүжих эх үүсвэрээс төвлөрүүлсэн 1.5 сая төгрөгийг хасалгүй тайлагнасан, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 0.42 төгрөгөөр дутуу тайлагнасан, нийт 3.4 сая төгрөгийн алдааг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийтдээ 218.8 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 19.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 199.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Үүнээс тус байгууллагын даргын өөртөө хамаарал бүхий этгээдэд хууль бус шийдвэр гаргаж олгосон профессорын нэмэгдэл, Эхо-гийн үзлэг хавсарсны нэмэгдэл, дээд шатны байгууллагын тушаалаар баталсан шийдвэрийг зөрчиж нийгмийн ажилтанд олгосон халдвар судлаачийн нэмэгдэл, бүх эмч нарт болон өөртөө илүү цагаар ажилласныг нотлох баримтгүй хавтгайруулан олгосон 21.3 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс, 2023 онд зарцуулсан 102.8 сая төгрөгийн эмийн тайлан гаргаагүй, шатахууны зардлаас хувь хүмүүст хавтгайруулан бичсэн 43.4 сая шатахууны асуудлуудыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, албан үүргээ биелүүлээгүй 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар 19.6 сая төгрөгийн зөрчилд зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1. Ажилчдын цалингаас нийтдээ 62,390.5 мянган төгрөгийн татварыг суутган авч, 53,168.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 9,221.5 мянган төгрөгийн татварыг төсөвт дутуу төвлөрүүлэн, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д "Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төвлөрүүлсэн 9.2 сая төгрөгийг байгууллагын төсвөөс нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Нэр бүхий эмч нарт цалингийн зардлаас холбогдох хууль, тогтоомж, зөрчиж профессорын нэмэгдэлд 1,184.4 мянган төгрөг, дээд шатны байгууллагын шийдвэрийг зөрчиж ЭХО-ийн үзлэг, халдвар судлагчийг хавсарсны нэмэгдэлд 4,107.1 мянган төгрөг, яаралтай эмчийн 6 сарын сургалтад суусан буюу ажиллаагүй хугацаанд 3,475.3 мянган төгрөгийн цалин олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1-т "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*", 5.1.4-д "*үнэн зөв байх*" , Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам” 3 дугаар хавсралтын 2, 4 дэх заалтууд, Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай “ 2015 оны 97, 56 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөө санхүүжүүлэх журам”-ын 3.2.1, 3.3, 4.2.3 дахь заалтууд, ........................................ хэт авианы оношилгооны 3 сарын сургалтад суусан мэс заслын эмчид нэмэгдэл цалин олгохгүй талаар аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 73 дугаар албан бичгээр хүргүүлсэн хариуг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль журам зөрчиж байгууллагын төсвөөс үр ашиггүй зарцуулсан 8.7 сая төгрөгийг хавсралтад нэр бүхий хүмүүсээс нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар 199.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.Үүнд:

1.Тайлант онд 102.8 сая төгрөгийг эмийн тайлан гаргаагүй, эмийн бүртгэл тооцоо хангалтгүй, эмийн бүртгэл хөтлөлт, зарцуулалтад холбогдох журмын дагуу давхар хяналт хэрэгжээгүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, шатахууны зардлаас хувь хүмүүст 43.4 сая төгрөгийн шатахууны талон бичиж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан ба үүнээс нэр бүхий 4 эмч 4.3 сая төгрөгийг шатахууны талон бичсэн, бүх эмч нарт хавтгайруулан нотлох баримтгүйгээр 21.3 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон, бараа үйлчилгээний зардалд 27.4 сая төгрөгийн өр үүсгэж ажилласан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.2-д "тасралтгүй байх", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дараалаар гүйцэтгэнэ”, 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Эмийн бүртгэл тооцоо, дотоод хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангах, шатахууныг хувь хүмүүст олгодог зөрчлийг таслан зогсоох, өр авлага үүсгэхгүй ажиллах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2.Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10.7 сая төгрөгийн 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32.2 сая төгрөгийн 5 гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 38.7 сая төгрөгийн 3 шийдвэр, 27.4 сая төгрөгийн 6 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 898.3 сая төгрөгийн 26 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан, мэдээлсэн байдлын хэрэгжилт 65.9 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6 дугаар зүйлийн 6.4.8-т “...... *төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр*” гэснийг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансанд мэдээлээгүй цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10.7 сая төгрөгийн 1 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32.2 сая төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 38.7 сая төгрөгийн 3 шийдвэр, өр үүсгэсэн 27.4 сая төгрөгийн 6 шийдвэрийг нөхөж байршуулж, зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

<u>1.1.Илрүүлэлт:</u>

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцээгүй, АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>1.2. Өгсөн зөвлөмж:</u>

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, ойлголтоо сайжруулах;

*Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НДШ-ийн 0.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан | 1 | 272.2 | 1 | 272.2 | | | 1 | 272.2 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд халаалтын зардлын гүйцэтгэлийг 1.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан. | 1 | 1,540.4 | | | 1 | 1,540.4 | 1 | 1,540.4 | | | | |
| ТГТ-ийн орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрээс төвлөрүүлэх шилжүүлгийг хасалгүй илүү тайлагнасан | 1 | 1,540.4 | | | 1 | 1,540.4 | 1 | 1,540.4 | | | | |
| Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 0.42 төгрөгөөр дутуу тайлагнасан, | 1 | 0.004 | 1 | 0.004 | | | 1 | 0.004 | | | | |
| Дүн | **4** | **3,353.0** | **2** | **272.2** | **2** | **3,080.8** | **4** | **3,353.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цалингаас суутгасан 9.2 сая төгрөгийн ХХОАТ-ыг төсөвт дутуу төвлөрүүлсэн | 1 | 9,221,5 | 1 | 9,221,5 | | | | | | | | |
| Нэр бүхий эмч нарт профессорын нэмэгдэл, ЭХО-гийн үзлэг, халдвар судлагч хавсарсны нэмэгдэл, 6 сарын сургалтад суусан хугацаанд цалин олгосон | 1 | 8,766.9 | 1 | 8,766,9 | | | | | | | | |
| Эмийн тайлан гаргаагүй, хувь хүмүүст шатахууны талон олгосон, эмч нарт хавтгайруулан илүү цагийн нэмэгдэл олгосон, өр үүсгэсэн | 1 | 199,191.8 | | | 1 | 199,191.8 | | | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Хариуцлага тооцуулсан албан шаардлага | | | | | | | | | **2** | **6** | | |
| Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | | | | | | | | | | 1 | |
| **Дүн** | **4** | **217,180.2** | **2** | **17,988.4** | **1** | **199,191.8** | **1** | | **2** | **6** | **1** | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10.7 сая төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 32.2 сая төгрөгийн 5 гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 38.7 сая төгрөгийн 3 шийдвэр, 27.4 сая төгрөгийн 6 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй. | 1 | 108,910.3 | | | 1 | 108,910.3 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | 1 | 108,910.3 | | | 1 | 108,910.3 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |